

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Өдөр -12
Шөнө -20

УЛС ТӨР

Л.БОЛД: ГАДААД ХАРИЛЦААГ
ИНГЭЖ ХӨГЖҮҮЛДЭГГҮЙ ЮМ,
Ц.МӨНХ-ОРГИЛ ОО

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ТЕНДЕР АВЧ ҮЗЭЭГҮЙ, ОФФШОР
ДАНСГҮЙ ТЭРБУМТАН САЙД

V нүүрт

Дугаарын 60 мөр

ЧУХАЛ СЭДЭВ

Онц байдал зарлах
болоогүй юу

МОНГОЛЧУУД ХЭЗЭЭ ШИНЭЛЭХ ВЭ

Н.ПУНЦАГБОЛД

Хятадын хойд болон зүүн бүс нутагт утаа ихэссэний улмаас тус улсын Үндэсний одон орон судлах төвөөс анх удаа түгшүүрийн улаан төвшин зарласан байна. Өнгөрсөн бямба гарагт энэ үйл явдал болжээ. Улмаар дээрх бүс нутгуудад олон зуун нислэг цуцлагдаж, хурдны зам болон үйлдвэрүүдийг хаасан аж.

Үргэлжлэл нь III нүүрт



МОНГОЛЫН
МЭДЭЭ

Манай сонины
I улирлын нэмэлт
захиалга
явагдаж байна

Захиалгын үнэ
19800



Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ДАВААХҮҮ

Сүүлийн жилүүдэд цагаан сараа хэдэн сарын хэдэнд тэмдэглэх асуудал иргэдийг багагүй төөрөгдөлд оруулдаг болоод байгаа билээ. Зурхайч бүр л өөр өөрсдийн таамаглалаа дэвшүүлж байгаа нь иргэдийг ийнхүү төөрөгдүүлдэг болсон. Тэгвэл энэ жил хэзээ цагаан сараа хийх талаар зурхайчид аль хэдийнэ маргалдаад эхэлсэн. Тиймээс бид энэ удаагийнхаа "Чухал сэдэв" буланд хамба лам нар болон зурхайчид хэрхэн байр сууриа илэрхийлсэнийг хүргэж байна.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



"МОНГОЛЫН МЭДЭЭ" СОНИН, WWW.MMINFO.MN САЙТЫНХАН ШИЛДГҮҮДЭЭ НЭРЛЭЛЭЭ

Б.ДАВАА

Нэгэн он улирч, 365 хоногтой шинэхэн хуанлийн хуудас эргэх үест аливаа байгууллага, хамт олон шинэ жилийн баяраа тэмдэглэж, тухайн ондоо ажил үйлс, хөдөлмөр, хичээл зүтгэлээрээ манлайлж чадсан шилдэг ажилтнуудаа шалгаруулдаг уламжлалтай. Энэ жишгээр манай сонин, сайтынхан ч мөн шинэ жилийн баяраа тэмдэглэж, шилдгүүдээ тодруулан өргөмжиллөө. Өдөр тутмын сонинны редакцийн "гал тогоо"-нд нөр их ажил үйлс өрнөн байдаг. Ургах нартай уралдан редакци руугаа яарч, үдшийн харанхуйгаар л гэрийн бараа хардаг сэтгүүлчийн ажил тийм ч амар биш. Эх оронд өрсөсөн шуурхай үйл явдлыг хоногийн 24 цагийн аль ч үед халуун цэг дээрээс нь түмэнд хүргэх хүндтэй, басхүү хатуухан үүрэг ч бидэнд бий. Төрд өргөсөн тангараггүй ч, тушаал авахад үргэлж бэлхэн байдаг үзэг, дэвтэрээс өөр зэвсэггүй сонинны "цэргүүд"-ээ, бид. Нийгмийн болж бүтэхгүй болгонтой тэмцэж, шүүмжилж, томчуудад нүд үзүүлэгдэх, цаашлаад ярилцлага авах гэж өдөржин хүлээх, халуун нар, ширүүн бороо, цасан шуургатайд ч ажрахгүй ажилласаар л явна. Гэсэн ч, бидэнд шантрах үе байдаггүй. Бичсэн нийтлэл, ярилцлага, сурвалжлага бүрийнх нь тоогоор нийгэм өөрчлөгдөж, тэр нь мянга мянган монгол айлын аж амьдрал шууд болон дам нөлөөлдөг учраас сэтгүүлчид бид мэргэжилдээ урамшиж, бас ирлэгдэж байдаг юм. Харин манай сонин, сайтынхан ёстой л нэг ажлын төлөө төрсөн

хамт олон доо. Зүгээр ч нэг хамт олон бус, нэг гэр бүл шиг л хүмүүс. Улирч буй онд бид бүгдээрээ л эрвийх дэргийгээрээ ажилласан. Бүгд л шилдэг байлаа. Гэхдээ уралдвал нэг нь түрүүлдэг хойно амжилт бүтээлээ дүгнэж цэгнэх шинэ жилээ өнгөрсөн сарын 28-нд тэмдэглэж, шилдгүүдээ тодруулсан юм. Ерөөлийн үг, болор хундагатай харшилдсан тэр үдшийн гол дүр нь яах аргагүй манай Харнуцлагатай нарийн бичгийн дарга Э.Энхцэцэг байлаа. Тэрбээр 2016 оны "Шилдгийн шилдэг ажилтан"-аар өргөмжлөгдөж, LED телевизорын эзэн болсон юм. Э.Энхцэцэг эгч минь ёстой л албан тушаал шигээ хариуцлагатай хүн дээ. Сониньхоо редакцид өглөө хамгийн эрт ирж, орой хамгийн сүүлд харихаас гадна манай "гал тогоо"-нд чанагдаж буй бүхий л мэдээ, материалын давс хужирьг нь тааруулж суудаг юм. Бас сайн удирдагч. Залуу сэтгүүлчиддээ үлгэрлэж, хамт олондоо хүндлэгдэж, мөн үнэлэгдэж чадсан хүндээ. Энэ шагнал түүний улирч буй онд гаргасан амжилт, нөр их хөдөлмөрийн үр дүн, ирж буй онд үүрэх их хариуцлагынх нь эхлэл байлаа. Харин Нийгэм, шуурхай мэдээллийн албаны дарга Н.Пунцагболд, Гэрэл зургийн албаны дарга Г.Аргуужин нар маань ажил үйлс, амжилт бүтээлээрээ бусдыгаа манлайлж "Шилдэг ажилтан"-аар тодорч, өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнууллаа. Шилдгүүдийн шагналыг "Монголын мэдээ" сонинны Ерөнхий эрхлэгч С.Гантогоо, орлогч эрхлэгч Ч.Чулуунцэцэг нар гардуулан өгч, 2017 ондоо илүү их амжилт гаргахыг хүсэн ерөөсөн юм.

ҮЗЭЛ БОДОЛ

М.ЭНХБОЛДЫН замыг хуулиар засч байгаа юу

Н.ПУНЦАГ

Шинэ он гарахтай зэрэгцээд л нэг сэдэв "хэрүүлийн алим" болоод байгаа нь Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болчихоод байна. Ерөөсөө энэ хуулийн төслүүд МАН-ын дарга М.Энхболдыг Ерөнхийлөгч болгоход чиглэсэн, бүх замыг нь зассан гэж хардах хүмүүс олон байна. Ямар сайндаа л МАХН-аас УИХ-д сууж байгаа ганц гишүүн болох О.Баасанхүү чадлынхаа хэрээр хашгираад байх вэ дээ. Гэхдээ яг ачиртаа МАН дотор

бөөн "алаан" болоод байгаа юм биш үү. Ерөнхийдөө М.Энхболд дарга өөрийнхөө эрх мэдлийг дээд цэгт нь хүргэх бүхий л арга замыг ашиглаж, урагшаа зүтгэж байна уу гэж хардахаар болчихлоо. Яг үнэн хэрэг дээрээ Ерөнхийлөгчийн сонгууль тийм ч их анхаарал татахгүй байгаа юм биш үү. Ерөнхийдөө У.Хүрэлсүх сайдын хэлээд байгаа л үнэн болж таарах гээд байна. Шадар сайд МАН-ын бага хурал дээр намынхаа нэлээд хатуухан шүүмжилж, томилгооноос авахуулаад бүх зүйл болохгүй байгааг хэлсэн.

Үргэлжлэл нь III нүүрт

ДЭЛХИЙ

Бүгд найрамдах нам ноёрхох цаг айсүй



Б.ДАВАА

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас нэр дэвшсэн үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп ялалт байгуулсан билээ. Тэрбээр энэ сарын 20-нд албан ёсоор Ерөнхийлөгчийн тангараг өргөх бол Барак Обамагийн бүрэн эрхийн хугацаа ч үүгээр дуусгавар болж, Цагаан ордноос нүүх юм. Тэгвэл энэ ёслолын дараа Бүгд Найрамдах нам 10 жилийн дараа Цагаан ордон, конгрессын дээд доод танхимд дахин ноёрхлоо тогтоох билээ.

Үргэлжлэл нь IV нүүрт

ХААН банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2484.00	2498.00	ФУНТ	2993.00
ЕВРО	2555.00	2622.00	РУБЛЬ	39.20
ИЕН	20.91	21.24	ЮАНЬ	356.00

Хугалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2486.00	2498.00	ФУНТ	3011.00
ЕВРО	2561.00	2642.00	РУБЛЬ	39.59
ИЕН	20.90	21.55	ЮАНЬ	357.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

БАЙНГЫН ХОРОО

Их сургуулиудын Удирдах зөвлөлийг шинэчилжээ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар төрийн өмчит их сургуулиудын Удирдах зөвлөлийг шинэчилжээ. Тухайлбал, нэгдүгээр сарын 02-ны өдөр МУИС, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулсан байна. МУИС-ийн Удирдах зөвлөл нийт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд даргаар нь ШУА-ийн жинхэнэ гишүүн, академич Д.Рэгдэл, орлогч даргаар БСШУСЯ-ны Боловсролын бодлогын газрын дарга Д.Эрдэнэчимэг ажиллаж юм байна. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн даргаар БСШУС-ын сайдын зөвлөх Н.Бэгз, орлогч даргаар БСШУСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Л.Цэдэвсүрэн нар тус тус ажиллахаар болжээ. Харин нэгдүгээр сарын 03-ны өдөр АШУУИС, ХААИС, СУИС, МУБИС-ийн Удирдах зөвлөлийг тус тус шинэчлэн байгуулжээ. АШУУИС-ийн Удирдах зөвлөлийн даргаар ШУА-ийн жинхэнэ гишүүн, доктор Т.Ган-Эрдэнэ, орлогч даргаар БСШУСЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга З.Энхболд нар томилогджээ. ХААИС-ийн Удирдах зөвлөлийн даргаар ШУА-ийн жинхэнэ гишүүн, доктор Б.Авид, орлогч даргаар БСШУСЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын дарга Д.Батмагнай нар томилогдсон байна. СУИС-ийн Удирдах зөвлөлийн даргаар БСШУС-ны Соёл, урлагийн бодлогын газрын дарга Н.Болд, орлогч даргаар А.Дашпэлжээ нар тус тус ажиллахаар боллоо. МУБИС-ийн Удирдах зөвлөлийн даргаар БСШУСЯ-ны Боловсролын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Мөнхбаатар, орлогч даргаар Биешин тамир, спортын бодлогын газрын дарга С.Чинбат нарыг тус тус томилжээ.

Л.БОЛД: Гадаад харилцааг ингэж хөгжүүлдэггүй юм,

Ц.МӨНХ-ОРГИЛ ОО



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ЖОТГОН

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Дипломат албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тухай, Монгол Улсын зарим Элчин сайдын яам, Ерөнхий консулын газрыг татан буулгах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн гишүүдийн олонхийн саналаар “Төслийг хэлэлцэх нь зүйтэй” хэмээн үзлээ. Дипломат албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хүрээнд дипломат төлөөлөгчийн газарт томилогдох томилогчийн хугацаа гурван жил байсныг дөрөв болгон нэмэгдүүлж байгаа юм. Мөн гадаад харилцааны салбарынхны цалин, нийгмийн хангамж тааруугаас хэлний өндөр мэдлэгтэй ажилтнууд хувийн хэвшилд шилжин ажиллах нь ихэсчээ. Иймээс Дипломат төлөөлөгчийн газарт ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах шаардлагатай гэж үзэн, хилийн чанадад ажиллагсдын цалин хөлсийг гурван жил тутамд Засгийн газраас шинэчлэн тогтоож байх. Хүүхдийн цэцэрлэгийн төлбөрийг төрөөс хариуцах, эхнэр буюу нөхөр нь төрийн албан хаагч бол ажлын байрыг нь хадгалах зэрэг нийгмийн баталгааг нь хангах зохицуулалтыг дээрх хуульд тусгажээ.

Хууль батлагдахад хүүхдийн цэцэрлэгийн төлбөрийн 300 мянга орчим ам.долларын зардал гарна. Тэгвэл энэхүү зардлыг 2017 оны зургадугаар сараас хаахаар төлөвлөж байгаа дөрвөн Дипломат төлөөлөгчийн газрын санхүүжилтийн зардлын хэмнэлт, мөн томилогчийн цагдаагаар орон тооны санхүүжилтийн зардлын хэмнэлтээс шийдвэрлэх бүрэн боломжтой гэж үзэж буй гэнэ. Харин Монгол Улсын зарим Элчин сайдын яам, Ерөнхий консулын газрыг татан буулгах тухай УИХ-ын тогтоолын төслийн хүрээнд Индонези, Бразил улсад

суугаа Элчин сайдын яам болон дипломат төлөөлөгчийн газар ажиллаж байгаа Япон улсын Осака хотод суугаа Монгол Улсын Ерөнхий консулын газар, БНХАУ-ын Хайлаар хотод суугаа Консулын газрыг тус, тус татан буулгах тухай асуудал хөндөгдөж байна. Хэлэлцүүлгийн шатанд, УИХ-ын гишүүн Н.Оюундарь “Дипломат төлөөлөгчийн газарт томилогдох томилогчийн хугацааг дөрвөн жил болгон нэмэгдүүлж байна. Ажлын хариуцлага алдвал яах вэ” гэдгийг тодруулаа. Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил “Ажлын хариуцлага алдсан тохиолдолд шууд чөлөөлнө. Гол нь эндээс томилогдох хугацааг нь дөрвөн жил болгон нэг жилээр нэмэгдүүлж өгч байгаа юм” гэдгийг тодотголоо. Харин УИХ-ын гишүүн Л.Болд “Засгийн газар дэндүү өрөвдөлтэй хуулийн төсөл оруулж ирлээ. Танилцуулгад байна, 35 хүүхдэд цэцэрлэгийн мөнгө гаргаж ирэхийн тулд зарим Элчин сайдын яам, Консулын газар татан буулгах болж буй юм байна. 300 мянган ам.доллар гаргаж ирэхийн тулд ингэж байгаа юм уу. Үүнийхээ оронд мөнгөө нэмчих л дээ. Ганцхан жижиг төслөөс татгалзахад л хүүхдийн цэцэрлэгийн мөнгө гаргаад ирнэ. Латин Америкийн тэр чигээр нь хариуцдаг газраа татан буулгах нь буруу. Японы талаас “Танайх консулын газраа татан буулгах нь буруу. Эргэж харах юм шүү” гээд хэлж байна. Гадаад харилцааг ингэж хөгжүүлдэггүй юм, Ц.Мөнх-Оргил оо” хэмээлээ. Тэгвэл УИХ-ын гишүүн Н.Энхболд “Хуулийн төслийг дэмжинэ. Л.Болд ганцаараа гадаад харилцааг мэддэг юм биш. Байнгын хороон дээр энэ асуудлыг ярьж чиглэл өгөөд Засгийн газраас оруулж ирж байгаа асуудал. Тогтоол гаргаад оруулж ирж байгааг Л.Болд мэдэж л байгаа байлгүй, байнгын хорооны гишүүн хүн. Ер нь Монголыг гадаадад төлөөлж байгаа дипломатуудын хувьд

зөвхөн хүүхдийнх нь асуудал биш цалин, тэтгэвэр нь ямар байдаг билээ, бид бүгд мэднэ. Монголоос хүн яваад очиход өөрсдийнхөө халааснаас мөнгө гаргаад дайлаад явуулах тохиолдол бий. Хүүхдээсээ болоод шаардлагынх нь дагуу ажиллуулах боломжгүй байгаа тохиолдол ч байгаа. Монгол бол маш хүнд нөхцөлдөө ордог” гэв. Ийнхүү байнгын хорооны хуралд оролцсон гишүүд хуулийн төслийг дэмжсэн тул УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахаар болж шийдвэрлэлээ.

Ж.Ганбаатар: Жижиг дунд үйлдвэрт гурван тэрбум төгрөг нарийлж байгаа бол одоо яахав дээ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны хуралдаанаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжлээ. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтад “жижиг, дунд үйлдвэр эрхлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, санхүү, татвар, зээл, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн бодлогыг тодорхойлох”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.13-т “Дотоодын үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжинэ” гэж тус тус заасныг үндэслэн боловсруулжээ. Хэлэлцүүлгийн үеэр Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайд П.Сэргэлэн “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар дамжуулан 2009-2016 оны хугацаанд нийт 745.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл

олгосон. Энэ зээлийн 83.5 хувийг эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан бөгөөд ингэснээр тухайн аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого нь дунджаар 20-30 хувиар нэмэгдсэн гэсэн дүн мэдээ байна. Мөн 2011 оноос эхлэн Сум хөгжүүлэх сангаар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд 1-3 хувийн хүүтэй, гурван жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээлийг олгосон. Энэ дэмжлэгийн үр дүнд орон нутагт 9.272 үйлдвэр, цех шинээр байгуулагдаж, 13.909 үйлдвэр, цех үйл ажиллагаагаа өргөтгөж, улсын хэмжээнд 32.9 мянган ажлын байр шинээр нэмэгдэн, 20.7 мянган ажлын байр хадгалагдаж үлдсэн байна” гэв.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, коглох уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу Засгийн газар баталснаар жижиг, дунд үйлдвэрт өрсөлдөөнийг бий болгож, экспортын чадавхийг дээшлүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлж, ДНБ өсөх зэрэг аж холбогдолтой гэж төсөл санаачлагчид үзэж байгаа юм. Хуралдааны үед УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн “Хуулийн төсөл энэ хэвээрээ УИХ-ын чуулганаар орох юм бол унах магадлалтай” гэдгийг хууль санаачлагчид сануулсан. Харин УИХ-ын гишүүн Н.Амарзаяа “Хэлэлцэх асуудлаа долоо хоногээр хойшлуулаад, хуулийн төслийг засч сайжруулаад оруулж ирвэл ямар вэ” гэдэг санал гаргасан юм. Гэвч хууль санаачлагч УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар “Хуулийн төслийг хойшлуулах шаардлагагүй. УИХ-ын чуулган дээр унавал тэр л биз. Том компаниуд нь 100, 100 тэрбумын боломж олдоод байдаг. Жижиг дунд үйлдвэрт гурван тэрбум төгрөг нарийлж байгаа

бол одоо яахав дээ” гэлээ. Харин УИХ-ын гишүүн Ч.Улаан “Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдээд УИХ-ын чуулганд шилжүүлэв. Гэхдээ нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээс өмнө Засгийн газрын нэгдсэн байр суурийг тодорхойлсон, тооцоо судалгаагаа тодорхой болгоод оруулж ирээрэй” гэв. Ийнхүү хуулийн төслийг хэлэлцэх эсэхээр санал хурааж Байнгын хорооны гишүүд 100 хувь дэмжсэнээр хуулийг төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр боллоо.

Тусгай сангийн тухай хуулийг хэлэлцэхийг хойшлууллаа

УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаан 14:55 цагт гишүүдийн 52.6 хувийн ирдгэйгээр эхэлсэн юм. Хуралдаанаар Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх байсан юм. Байнгын хорооны хуралдааны эхэнд УИХ-ын гишүүн Я.Содбаатар “УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зааснаар уг хуулийн төсөл Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд багтахгүй. Санхүү, мөнгөний асуудалтай холбоотой учир Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэгдэх ёстой. Тиймээс уг асуудлыг хэлэлцэхийг түр хойшлуулж, Эдийн засгийн байнгын хороотой хамтарсан хуралдаан хийж, хуулийн төслийг хэлэлцэе” гэсэн горимын санал гаргасан юм. Улмаар уг горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүд 100 хувь дэмжиж, хуулийн төслийг байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэхээр болж хойшлууллаа.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

АН-ын гишүүдийн бүртгэл маргааш дуусна

Ардчилсан намын даргад нэр дэвшиж буй таван нэр дэвшигч Дундговь аймгийн АН-ын гишүүд дэмжигчидтэйгээ уулзалт хийж байгаа аж. Энэ удаагийн намын даргад нэр дэвшигчид хамтдаа сурталчилгаагаа хийж байгаагаараа онцлогтой.

Оны өмнө таван нэр дэвшигч зүүн таван аймаг, Багануур дүүрэгт сурталчилгаагаа хийсэн. Намын даргын сонгуультай холбоотойгоор намынхаа гишүүдийн бүртгэлийг шинэчилж байгаа. Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан гишүүд намын

даргын сонгуульд саналаа өгөх эрхтэй болох юм. Хамгийн сүүлд авсан мэдээллээр АН-ын гишүүдээс 40 мянга нь гишүүний шинэчилсэн бүртгэлд хамрагджээ. Намын гишүүдийн шинэчилсэн бүртгэл маргааш дуусна.

С.Зоригийн амийг хөнөөсөн захиалагчийг ОЛНО ГЭВ

Ардчиллын алтан хараацай С.Зоригийн амийг зэрлэгээр хөнөөсөн хэрэг 18 жилийн дараа шүүхэд шилжиж, маш нууцын зэрэглэлтэй хэмээн зургаан удаа хаалттай хуралдаж, алх тасхийн гурван хүнд 24-25 жилийн ял оноож, гянданд хорихоор шийдвэрлэсэн. Шүүхээс шүүгдэгч Ц.Амгаланбаатар, Т.Чимгээ, Б.Содномдаржаа, нар нь С.Зоригийн амь насыг бусадтай бүлэглэж хулгайн

сэдэлтээр, захиалгаар, онц харгис хэрцгий аргаар санаатай хөнөөсөн хэмээн үзсэн юм. Тэгвэл олон нийтийн цахим сүлжээнд “С.Зоригийн амийг зэрлэгээр хөнөөсөн хэргийн захиалагч хэн байв” гэсэн таамаг өрнөөд буй. Үүний дагуу Улсын ерөнхий прокурорын газраас дээрх хэргийн захиалагчийг олох ажлын хэсэг байгуулсан гэнэ. Эл хэргийг шалгах хамтарсан ажлын хэсэгт Тагнуулын

ерөнхий газрын Мөрдөн байцаах хэлтэс, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын Онц хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтсийн мөрдөн байцаагчид багтсан байна. Уг ажлын хэсгийн ажилд Нийслэлийн прокурорын газраас хяналт тавихын зэрэгцээ хэргийг шуурхай шалгаж, шийдвэрлэхийг Ерөнхий прокурор М.Энх-Амгалан ажлын хэсэгт үүрэг болгожээ.

Д.Дамба-Очир гишүүн сэрүүн зүүднээсээ сэрээсэй

Сүүлийн үед Улаанбаатар хотын толгойныөвчинболоодбайгаутааны асуудлыг дээр, дооргүй ярих болоод байгаа. Үнэхээр ч утаа гамшгийн хэмжээнд хүрч эмнэлгүүд нь өвчиндөө шаналсан хүүхдүүдээр дүүрээд, шалаар нэг зулах болсон. Тиймээс ч утаа УИХ-ын төвшинд хүрч, асуудлыг хэлэлцэж эхлээд байгаа. Тэгвэл Орхон аймгийн 48 дугаар тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүн Д.Дамба-Очир утааны асуудлаар “Утаа гамшгийн хэмжээнд хүрсэн гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм шиг байна. Жил ирэх тусам утаа багасах бус улам нэмэгдээд байгаа. Тиймээс утаатай тэмцэх мөнхийг гадныханд өгөөд, гадны төслөөр хэрэгжүүлэх хэрэгжүүлэе” гэлээ. Түүний хэлж буйгаар гадныхан ирээд л биднийг утаанаас маань салгах юм байх. Гадаадыг шүтсэн Д.Дамба-Очир гишүүн сэрүүн зүүднээсээ сэрээсэй билээ.

ҮЗЭЛ БОДОЛ

ҮЗЭЛ БОДОЛ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Онцгой комиссын болоод бусад хурал дээр ч М.Энхболдын гэгдэх хүмүүст хатуухан сануулга өгч, ажлаа өөдтэйхэн хийхийг сануулаад байгаа. Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, хотын дарга С.Батболд гээд дурьдвал жишээ зөндөө л байна. Ерөнхийдөө У.Хүрэлсүх энэ нам нэг хүний эрх мэдлийн хэрэгсэл болж, хэтэрхий туйлширч байгааг хэлж, сануулж байгаа. Гэхдээ хүч нь хүрэх эсэхийг бүү мэд. Ямар ч байсан М.Энхболд өөрийнхөө эрх мэдлийг одоогийнхоос хавьгүй илүү нэмэх л замыг засаад яваад байгаа бололтой. Үндсэн хуулиар оролдохгүй, зүгээр л Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг өөрчиллөө гэхдээ өөрөөсөө өөр хүнд боломж өгөхөөргүй зүйл, заалтуудыг тусгах нь. Тухайлбал, МАХН-ын дарга Н.Энхбаярыг өрсөлдүүлэхгүй байх баталгаатай заалтыг оруулж өгч байгаа. Тэр нь “Сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан байх ёстой” гэсэн ганц заалт. Ердөө

Харин шүүмжлэл түүн дээр ирэх байв. Үүнийг, цаашлаад Үндсэн хуульд оруулах өөрчлөлт энэ тэрээр тэр маш нарийн тооцож, торгуулийн салааны даргаар Ж.Эрдэнэбатыг тавиад л “дайн”-д явуулчихгүй юу. Тэгээд өөрсдөө араас нь “довтолж”, нэр хүндтэй хэвээрээ үлдэх тактик барьсан ч байж болох. Улмаар Үндсэн хуулиа өөрчилж, бүх эрх мэдлийг Ерөнхий сайдын гарт нэгтгээд, өөрөө танхимын тэргүүн болох тун ч боловсролгүй төлөвлөгөөгөө биелүүлнэ дээ. Ийм л нөхцөл байдал руу манай улс ороод байх шиг байна. Тэгэхээр Ерөнхийлөгчийн сонгууль болохгүй ч байж магадгүй. Гэхдээ МАН наанаа

М.ЭНХБОЛДЫН ЗАМЫГ ХУУЛИАР ЗАСЧ БАЙГАА ЮУ

л энэ заалт байхад Солонгос руу гүйдэлтэй байсан Намбар гуайн хүүг Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх боломжийг нь хааж байгаа. Цаашлаад АН-аас хүчтэй өрсөлдөх боломжтой хүмүүсийг ч хаасан заалтууд энэ хуульд орж магадгүй. Магадгүй ч гэж дээ, орох байх. Одоо нөгөө талаас нь хараад үзье. МАН парламентад олонх болж, 65 суудал авсан. М.Энхболд дарга юу гэж л хэлнэ, түүнийг нь бохь зажлангаа дагаж, товчлуур дарах “бор халзан хонь” МАН-аар л дүүрэн байна.

Тийм болохоор олонх болсноороо далимдуулж Үндсэн хуульд өөрчлөлт оруулах нэг хувилбар байж болж байна. Угаасаа 2016 оны сонгуулийн өмнө МАН-ынхан 21 аймгаар явсан. Тэгж явахдаа Үндсэн хуулийн өөрчлөлтийг түлхүү ярьж байлаа. Үндсэндээ Ерөнхий сайдын эрх мэдлийг тулгалт нь нэмж, Ерөнхийлөгчийг парламентаас томилж, бэлгэдэл төдий байхаар өөрчлөх гээд байгаа. Энэ өөрчлөлтийг хийхгүй гэх газар байхгүй. Энэ оны зун Ерөнхийлөгчийн сонгууль болно. Түүнээс өмнө Үндсэн хуульд өөрчлөлт оруулах боломж эрх баригчдад хангалттай бий. Хэрвээ Үндсэн хуулиа өөрчлөөд орхивол Ерөнхийлөгч гэдэг зүгээр л бэлгэдэл төдий болох байх. Одоогийн байгаа эрх мэдэл нь бүгд хумигдана. Тийм болохоор Ерөнхийлөгч болох гэж зүтгэх хүн тийм ч олон гарахгүй байх. М.Энхболд дарга ч гэсэн Үндсэн хуулинд аа өөрчлөлт оруулж аваад, өөрөө Ерөнхий сайдын суудлаа авах байлгүй. Тэгээд ч ялсан намын дарга Ерөнхий сайд байх ёстой шүү дээ. Мань хүн л Ж.Эрдэнэбатыг торгуулын суманд явуулчихсан болохоос биш. Өөрөөр хэлбэл, улс орны эдийн засаг хүндхэн байгаа. Ж.Эрдэнэбатын Засгийн газар өнөөдрийг хүртэл тийм ч сайн ажиллаагүй. УИХ-ын болоод МАН-ын дарга М.Энхболд ч гэсэн түүнийг нь хэлж, шүүмжлэлийн үг унагаад амжсан. Тэгвэл мань хүн өөрөө Ерөнхий сайд болсон гэж бодоод үзье. Тэглээ гээд юу өөрчлөгдөх байв. Өнөөдрийн нөхцөл байдал хэвээрээ л байх байлаа шүү дээ. М.Энхболд Ерөнхий сайд боллоо гээд манай улсын орлого өсч, томоохон төслүүд хөдөлж, өр шир дарагдчихгүй. Байх ёстой юм байгаагаараа л байна.

эв нэгдэлтэй юм шиг боловч цаанаа бас тодорхой фракцитай л нам. Тийм болохоор М.Энхболд даргын энэ бүх үйлдлийг таалахгүй байгаа хүмүүс мэдээж бий. Ц.Нямдорж гишүүнээс авахуулаад Шадар сайд У.Хүрэлсүх тэргүүтэй хүмүүс түүний энэ нарийн төлөвлөгөөг үл таашааж, нам доторх булхай луйвар, сандал суудлын наймаагаа хатуухан шүүмжилж байгаа байх. Ц.Нямдорж гишүүнд бол Ерөнхийлөгч болох санаа байх шиг байгаа юм. Гэхдээ Үндсэн хуульд өөрчлөлт ороод, Ерөнхийлөгч гэдэг зүгээр л нэр төдий албан тушаал, бэлгэдэл болчихвол түүнд таалагдахгүй л болов уу. Тэгэхээр нөхцөл байдлыг эсэргүүцнэ. У.Хүрэлсүх сайдын хувьд нам доторх томилгооноос авахуулаад М.Энхболдын нөлөө улам томорч, хувцсан дээр туссан шар тос шиг нүүж байгаа. Дээрээс нь томилгоо, хийж байгаа ажил нь ард түмэнд таалагдахгүй, МАН руу эргэсэн иргэдийн итгэл бага багаар буурч буй учир асуудлыг арай өөрөөр хаж байгаа биз. Гэх мэтээр МАН дотор нэлээд юм болж байна. Ж.Энхбаяр гэж нэг хүн намынхнаасаа нэлээд харшилж эхэлсэн. Дотроо бас “алаан” болоод байгаа л юм шиг харгалддаг. Энэ мэт чимээгүй толхилцоон нэг л өдөр тэсрэх байх даа. Харин хэн нь тэсч үлдэхийг цаг хугацаа харуулах буй за.

Дугаарын **60** мөр

Онц байдал зарлах болоогүй юу

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Ер нь Бээжин хотын агаарын бохирдол дээд цэгтээ хүрч, Хятадын Засгийн газраас онц байдал, түгшүүр зарлаж, олон үйлдвэрийг хаасан талаар мэдээлэл байнга л гарч байгаа. Ерөөсөө Хятад улс агаарын бохирдолтой тэмцэхийн тулд зоригтой, дорвитой арга хэмжээг авч хэрэгжүүлж буй. Он хуучинтэй машиныг замын хөдөлгөөнд оролцохыг шууд хориглох шийдвэрийг хүртэл гаргасан жишээ бий. Гэтэл манайд яаж байна, утаатай тэмцэх талаар ярьсаар байгаад л таарч байна. Өнөөдөр хүртэл утаатай яаж тэмцэх талаар санаа оноо уралдуулсан хэдэн хүн саарал ордноор дүүрэн байна. Яасан ч удаан санаа оноогоо уралдуулдаг юм. Ямар ч олон жил тэмцэж байгаа дүр үзүүлдэг юм билээ. Тэр хооронд зөвхөн агаарын бохирдлын улмаас Монгол Улс хэчнээн хүнээ алдав. Утаанаас болж жилд 100-200 хүүхэд амь насаа алдаж байна. Тийм байхад утаатай тэмцэх санал санаачилгаа ярьсаар л. Яасан ч гаргаж дуусдаггүй санаа байдаг юм. Дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бил үү. “Утаагүй” тодотголтой

зуух тарааж, нэг компанийн ашгийг нэмснээс өөр юу хийв ээ. Юу ч хийгээгүй шүү дээ. Одоо утааны үед онц байдал зарлах болоогүй юу. Өнөөдөр ч хамаагүй онц байдал зарлахаар л болчихоод байна. Тэгэхдээ зүгээр л зарлаад өнгөрөх биш Хятад шийдвэртэй арга хэмжээ авъя л даа. Саяхан даа, тодорхой хэсэг газарт нүүрс түлэхийг хориглолоо гээд л сүр болж байсан. Даанч шийдвэрээ хэрэгжүүлж чадаагүй л болохоос. Худлаа, үнэн утаатай тэмцэж байна гэж хий мөнгө үрж байхаар нэг л дорвитой шийдвэр гаргаад, түүнийгээ хэрэгжүүлэх хөрөнгө зарж яагаад болохгүй гэж. Өнөөдөр Улаанбаатар хотод онц байдал зарлахаар хэмжээнд үнэхээр хүрчихэж. Тодорхой бүсүүдэд утаа гамшгийн хэмжээнээсээ хэд дахин давчихсан. Хүн амьдрахын ч арга алга. Монголчууд бид хэзэргүй болохоороор л тэсээд амьдраад байгаа байх. Ер нь яг ид хүйтэн, утааны улиралд бага ангийн сурагчдыг сар амраадаг баймаар байна. Одоо бол 1-5 дугаар ангийнхан 21 хоног амарч байгаа. Энэ сарын 19-нд хичээлдээ орно. Амралтыг ингэж бага тогтоож ер нь яадаг юм. Бага

ангийн сурагчдыг сар, дунд ангийнхныг нь 21, томчуудыг нь 14 хоног амраахад болохгүй юм байхгүй. Нэгдүгээр сард бүтэн амраагаад, хавар жаахан сунаад хичээллэхчхэнэ л биз. Зургадугаар сарын 1-нд амрах ёстой байсан бол 15-ныг хүртэл хичээллээд л болно шүү дээ. Ингэвэл бага ангийн хүүхдүүд ханиад томуу хүрэх нь багасна. Гэртээ хэвтээд, гадаа гарч утаа амьсгалахгүй бол болоод явчихна. Зарим нь бүр хөдөө яваад, цэвэр агаарт хэд хоночихно шүү дээ. Өнөөдөр манай улсад олон асуудал байгаа. Өр шир энэ тэрээс авахуулаад. Гэхдээ түүнээс илүү нэг асуудал байгаа нь хүний эрүүл мэнд ямар ч баталгагүй болчихлоо. Гэтэл манай засгийнхан огт ажрахгүй, иргэдээ хайрлаж гамнахгүй байна. Онц байдал зарлах ёстой байтал тэгэхгүй гүрийсээр л. Харин 1.3 тэрбум хүнтэй Хятад яаж байна, агаарын бохирдол хэтрээд ирэхээр шууд онц байдал зарлаад, иргэдийнхээ эрүүл мэндийн бодож байна шүү дээ. Манайд бол огт эсрэгээрээ. Юун иргэдийн эрүүл мэндийг бодох. Харин утааг далимдуулж ашиг олохоо л бодоод байна. Бид ийм л удирдагчтай байна даа.



Дэлхийн хөгжлийг Монголд

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ - 2016



Шангри-Ла цогцолбор

Монголд анх удаа олон улсын 5 одтой зочид буудлын сүлжээ, оффис, худалдаа үйлчилгээний иж бүрэн цогцолбор ашиглалтанд оров



Юнител 4G LTE сүлжээ

Монголд анх удаа 4G LTE сүлжээг орон даяар нэвтрүүллээ



ASEM Village хотхон

Монголд анх удаа дэлхийн 50 гаруй орны төр, засгийн тэргүүнүүд, хүндэт зочид байрлах хотхонг барьж байгуулав



Кока-Кола үйлдвэрийн хаягдал ус цэвэршүүлэх байгууламж

Монголд анх удаа үйлдвэрийн хаягдал ус цэвэршүүлэх байгууламж бүрэн хэмжээгээр ажиллаж байна

Эдгээр бүтээн байгуулалтын

Хөрөнгө оруулалт:

1,4 их наяд төгрөг

Шинээр бий болгосон ажлын байр:

600 гаруй

Нийт

Дотоодын туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчид

2,100

Ажилласан хүмүүсийн тоо

19,000

Компанийн нийгмийн хариуцлагын 70 орчим төсөл, хөтөлбөр хэрэгжлээ



ДЭЛХИЙ

Бүгд найрамдах нам ЦОЁР УОХ ЦАГАА ИЙСҮЙ



Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

АНУ-ын завсрын сонгуульд Бүгд найрамдах нам конгрессын доод, дээд танхимд олонхи болж, Барак Обама доголлон нугас болж хоцорсон юм. Тэгвэл эдүгээ цаг үе өөрчлөгдөж, Ерөнхийлөгчөөр нь БНН-ын гишүүн сонгогдож, конгрессын дээд, доод танхимд ч БНН дахин ноёрхлоо тогтоосон учир цаашдаа Барак Обамагийн санаачлан баталсан эрүүл мэндийн тогтолцооны шинэчлэлтээс эхлээд түүнийг Ерөнхийлөгч байх үед баримталж байсан улс төрийн бодлого бүхэлдээ өөрчлөгдөх бололтой. Ийм чиглэлийг ч БНН-ынхан барьж эхэлсэн байна. Тодруулбал,

Шинээр сонгогдсон АНУ-ын Конгрессын гишүүд хуралдаж, Бүгд Найрамдах намын гишүүд Ерөнхийлөгч Барак Обамагийн баталсан эрүүл мэндийн тухай хуулийг дахин хэлэлцсэн байна. Өнгөрсөн оны арваннэгдүгээр сард болсон сонгуулийн дараа Бүгд Найрамдах нам сенат болон Төлөөлөгчдийн танхимд олонхи болсон. Тэгвэл тэдний анхны хуралдааны үеэр сенатын танхимын Төсвийн байнгын хорооны дарга “Obamacare” гэдэг эрүүл мэндийн тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг өргөн барьсан байна. АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа Д.Трам ч “Obamacare” хуулийг үр дүнгүй, зардал ихтэй хэмээн твиттер хуудсаараа дамжуулан байр сууриа илэрхийлээд амжлаа.

Түүний хувьд сонгуулийн кампанит ажлынхаа үеэр уг хуулийг үргэлжлүүлэх шалтгаан байгаа эсэхийг хянаж үзнэ гэдгээ амласан юм. Түүнчлэн, Ардчилсан намын гишүүдийн хувьд эрүүл мэндийн хуулийн шинэчлэлийг цаашид ч үргэлжлүүлэх саналтай байгаа аж. Ямартай ч, уг асуудалтай холбогдуулан БНН яаралтай хурал зарлаж, хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэжээ. Д.Трампын Засгийн газрын гишүүдийг Сенатын танхим удахгүй батлана. Харин Төрийн нарийн бичгийн даргаар томилогдох гэж буй Рекс Тиллерсоны тухайд хоёр намын гишүүд ихэд санаа зовж байгаагаа илэрхийлээд байна. Учир нь тэрбээр ОХУ-тай нэлээд ойр харилцаатай юм. Одоо-

гоор 100 суудалтай конгрессын дээд танхимд БНН-ынхан 52, Ардчилсан намын гишүүд 48 бий. Харин доод танхимын 241 нь БНН, 194 нь Ардчилсан намын төлөөлөгчид байгаа билээ. Иймээс үл хөдлөх бизнесмен эр Ерөнхийлөгчийн тангарагаа өргөсний дараа АНУ-ын улс төрийн ертөнцөд томоохон эргэлтүүд гарах төлөв ажиглагдаж байгаа юм. Дашрамд дурьдахад, АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгч Д.Трамд анхны хэвлэлийн бага хурлаа энэ сарын 11-нд хийхээр төлөвлөнгийн орон нутгийн зарим хэвлэлд мэдээлжээ. Ерөнхийлөгчийн сонгуульд ялсныхаа дараа тэрбээр өнгөрсөн сард хэвлэлийн бага хурал зарлана гэж мэдэгдэж байсан ч, хугацаа нь хойшлуулаад байсан юм.

Пак Гын Хэ цэцийн хуралд оролцохоос татгалзжээ

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг уншиж танилцуулах шүүх хуралд ирээгүй байна. Энэ хурлын үеэр хэд хэдэн дуулиант хэрэгт холбогдуулан түүнийг албан тушаалаас нь түдгэлзүүлсэн талаарх баримт нотолгоонуудыг уншиж танилцуулахаар төлөвлөсөн байжээ. Өнгөрсөн сард БНСУ-ын парламент Пак Гын Хэ албан тушаалаас нь түдгэлзүүлсэнтэй холбоотойгоор Үндсэн хуулийн цэцийн гишүүд парламентын шийдвэр зөв эсэхийг нягтлахаар өчигдөр хуралдсан байна. Гэтэл Пак Гын Хэ энэ хуралд ирээгүй тул анхдагч нотолгоонуудыг танилцуулах хурал хойшлогджээ. Хуульд заасны дагуу Пак Гын Хэ гэрээ гаргагч дуудан авчирсан байх ёстой гэнэ. Үндсэн хуулийн цэцийн хурлын дараа БНСУ-ын парламентын шүүхийн хорооны дарга Кеон Сонг-донг мэдэгдэл хийхдээ, Пак Гын Хэ ёс зүйтэй байж, дуулиант хэргүүдийн нотолгоо баримтыг шүүхийн өмнө ил тод болгох ёстой гэсэн байна.

Филиппиний шоронгоос 158 ялтан оргожээ

Филиппиний өмнөд этгээдийн Минданао арлын Котабаты мужийн шорон руу өчигдөр өглөө тус улсын MILF гэх лалын шашны зэвсэгт босогчид халдаж, ажил үүргээ гүйцэтгэж явсан нэг харгалзахчийн амийн бүрэлгэж, 158 ялтныг суллажээ. Босогчид Котабаты мужийн Кидапаван хотод байрладаг шорон руу халдсан байна. Тус шоронд тухайн үед нийтдээ 1511 ялтан, 24 харгалзахч байжээ. Харин Засгийн газраа эсэргүүцэгч босогчид 100 гаруй хүний бүрэлдэхүүнтэй байсан төдийгүй хоёр цаг орчим хугацаанд буудалцаан болсон байна. Халдлагад өртсөн шоронгийн



дарга орон нутгийн “ABS-CBN” сувагт ярилцлага өгөхдөө “Босогчид шоронд ял эдэлж байсан хамсаатнуудаа суллах зорилготой байсан” гэдгийг онцолжээ. Бүрэн зэвсэглэсэн босогчид шорон руу халдаж, хуягуудтай буудалцаж байх хооронд ялтнууд орны цагаан хэрэггэл ашиглан оргож байсан гэнэ. Одоогоор цагдаа, цэргийнхэн оргосон ялтнуудыг эрэн хайх ажиллагааг эхлүүлжээ. Минданао арлын өмнөд хэсэгт сүүлийн арав гаруй жилийн турш лалын шашны тус бүлэглэл салан тусгаарлах хөдөлгөөнийг өрнүүлж, Засгийн газрын армитай мөргөөн үүсгэх болсон байна. Мөн сүүлийн үед тэдний зарим нь хэт даврагч “Лалын улс” бүлэглэлийг дэмжихээ тангараглах болжээ.

МЭДЭЭЛЭЛ


ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ 2017 ОНЫХОО АЖИЛДАА ОРЛОО

Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат засаг төрөөс дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга болон харьяа байгууллага, бодлогын газрын дарга нартай 2017 оны үр дүнгийн гэрээг өнөөдөр байгууллаа. Энэхүү гэрээнд шинэ ондоо хэрэгжүүлэх 7 зорилт, 26 арга хэмжээний хүрээнд хийгдэх 192 ажлын төлөвлөгөө багтсан юм. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, зам тээврийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үр ашгийг нэмэгдүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн томоохон ажлуудыг хийхээр энэхүү гэрээнд тусгасан байна.

Үр дүнгийн гэрээ байгуулах үеэр сайд Д.Ганбат “Бүрэн хангалттай үнэлгээ авч, үр дүнгийн гэрээгээ байгуулж байгаан тусгаарлагууддаа баяр хүргэж, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүтээлчээр хэрэгжүүлж ажиллахыг хүсье. Засгийн газраас зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн та бүхнээс ихээхэн хамаарах тул зөв зорилго, оновчтой зохион байгуулалт, захиргааны удирдлагаар хангаж, шинээр сэтгэж ажиллах ёстой” хэмээн онцлон тэмдэглэв.

Мөн Зам, тээврийн хөгжлийн яам 2017 оныг “Бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх жил” болгон зарласан бөгөөд энэ хүрээнд томоохон төсөл хөтөлбөрүүдийг хийж, хэрэгжүүлэх талаараа танилцуулсан юм.

Тухайлбал, авто замын салбарт олон улсын авто замын сүлжээ буюу Азийн авто замын сүлжээний АН4 (баруун босоо тэнхлэгийн авто зам болох Ярант-Улаанбайшинт) чиглэлийн авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэх томоохон зорилтийг дэвшүүлсэн байна. Мөн бүх аймгийн төвийг



нийслэл хоттой авто замаар холбох, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хэсгийг үргэлжлүүлэх, Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамыг шинэчлэн өргөтгөх, Улаанбаатар Олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам барилгын ажлыг зохион ажлуулахаар төлөвлөжээ.

Мөн гэрээний хугацаанд “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлж, “Хөт-Бичигт” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулан, барилгын ажлыг эхлүүлэх юм байна. Түүнчлэн Нарийнсухайт—Шивээхүрэн чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлж, Зүүнбаян - Ханги” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах томоохон ажлуудыг төлөвлөж буй. “Богд хан төмөр зам” төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж, Эрдэнэт - Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлснээр улс орны эдийн засагт ихээхэн ач холбогдолтой талаар танилцууллаа.

Автотээврийн салбарт Герман, Чех, Польш улстай олон улсын авто тээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцрээр байгуулах чиглэлээр ажиллана гэдгийг тус яамнаас мэдээлсэн. Мөн Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд цахим системийг нэвтрүүлэх, тээврийн хэрэгслийн бүртгэл

хийх, бүртгэлийн дугаар олгох үйлчилгээнд цахим тогтолцоог бүрдүүлэх, Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх зэрэг иргэдэд чиглэсэн томоохон ажлуудыг хийж хэрэгжүүлэх аж. Замын хөдөлгөөнийг аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог бүрдүүлэх, олон улсын болон улсын чанартай авто замын дагуу үйлчилгээний байгууламжууд барьж байгуулах ажлыг эхлүүлэх зэрэг ажлыг Зам, тээврийн хөгжлийн яам энэ оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө багтаагаад байна.

Тус яамнаас иргэний нисэхийн салбарт хэд хэдэн зорилт дэвшүүлж, аймгуудын нисэх онгоцны буудлыг шинэчлэн өргөтгөх, агаарын замуудыг шинэчлэн тогтооход дэмжлэг үзүүлэхээс гадна олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежментийн концессын гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх, нисэх буудлыг ашиглалтад оруулахад холбогдох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх зэрэг томоохон арга хэмжээг 2017 оны төлөвлөгөөндөө тусгажээ. Мөн зам тээврийн салбарт мөрдөж буй хуулиудын шинэчлэсэн найруулгын төслийг боловсруулж батлуулах, тээврийн салбарын төсөл, арга хэмжээг судалж, эрх зүйн зохицуулалтуудыг хийх зэрэг бодлогын ажлуудыг ч төлөвлөж байгаа аж.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт

малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн АМГТ-ын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 4 дүгээр шийдвэрээр цуцалсныг мэдэгдэж байна.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	XV-018135	2015.04.29	Увс	Өндөрхангай	Бурхант	Геоплан ресурс ХХК
2	XV-020465	2008.11.14	Өмнөговь	Баяндалай, Ноён, Сэврэй	Тэнүүн-1	Мөнхлөвра ХХК
3	XV-020464	2008.11.14	Өмнөговь	Баяндалай, Ноён	Тэнүүн-1	Гоулден эссэнс монголиа ХХК
4	XV-017649	2014.10.29	Баянхонгор	Бөмбөгөр, Галуут	Товдог хайрхан уул	Эс Кью Эс ХХК
5	MV-020482	2002.10.25	Төв	Лүн	Шандын ам	ЛМО майнинг ХХК
6	XV-014371	2008.10.29	Дундговь	Цагаандэлгэр	Замын улаан	Эхлэл-Ургац ХХК
7	XV-019151	2015.10.29	Дорноговь	Сайхандулаан	Урд залаа	Мегатек мануфактуринг монголиа ХХК
8	XV-019230	2015.11.02	Сэлэнгэ	Орхонтуул	Өвөр булгийн хавцал	Демситрейд ХХК
9	MV-012162	2006.11.02	Дундговь	Баянжаргалан	Яст	Эм Си Ти Ти ХХК
10	XV-019109	2015.11.05	Хэнтий	Хэрлэн	Бек	Самат голд ХХК
11	XV-014411	2008.11.06	Дундговь	Дэлгэрхангай	Ширээгийн хөндий	Эрдэнэгинос ХХК

АМГТ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын хайгуулын

тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн АМГТ-ын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 5 дугаар шийдвэрээр цуцалсныг мэдэгдэж байна.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	XV-015152	2009.09.23	Булган	Бүрэгхангай	Захцаг уул	Фокусметал майнинг ХХК
2	XV-012818	2007.10.15	Дорнод	Дашбалбар	Мухар	Эм Энд Эм ХХК
3	XV-017505	2007.08.21	Өмнөговь	Номгон	Далан	Этүгэн-Эе ХХК
4	XV-012648	2007.08.21	Өмнөговь	Номгон	Далан	Этүгэн-Эе ХХК
5	MV-002449	2000.07.21	Хэнтий	Жаргалтхаан	Хадагтайн	Чандмань-Эрдэс ХХК
6	MV-018434	2015.04.07	Төв	Баянжаргалан	Шанаган	Штайнколе ХХК
7	MV-008766	2003.08.26	Булган	Сайхан	Эрэн ихэр уул	Пибодвинсвэй ресорсиз ХХК
8	MV-017589	2006.05.22	Улаанбаатар	Багахангай	Мааньт	Кинова ХХК

АМГТ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

ЧУХАЛ СЭДЭВ

МОНГОЛЧУУД

М.Намсрай: Монголчууд энэ жил нэгдүгээр сарын 28-нд шинэлэх нь зүйтэй

/Монголын үндэсний чөлөөт зурхайчдын нэгдсэн холбооны ерөнхийлөгч, шар зурхайч/

Монголчууд бид цагаан сараа 1807-2016 оны хооронд 209 удаа тэмдэглэхдээ 134 удаа буруу, 75 удаа зөв өдөр шинэллээ. Түвдийн зурхайгаар цагаан сараа тэмдэглэвэл 2016-2046 хооронд дахиад 23 удаа буруу шинэлэхээр байна. Шинэлэх ёсоо буруу өдөр товлосноос болж тухайн зөрүүтэй өдрүүдэд мэндэлсэн хүүхдүүд амьдралынхаа туршид буруу жилтэй, буруу төөрөгтэй амьдарна. Тухайлбал, ирэх оны нэгдүгээр сарын 28-наас хоёрдугаар сарын 27-ны хооронд мэндэлсэн хүүхдүүд Монгол шар зурхайгаар тахиа, Төгс буянт зурхайгаар мичин жилтэй болох нь. Төгс буянт зурхайнхан энэ жилийн цагаан сарыг хоёрдугаар сарын 28-нд эхэлнэ гэж үзэж

байгаа нь буруу. Монголчууд цагаан сараа нэгдүгээр сарын 28-нд тэмдэглэх нь зүйтэй.

Хубилай хааны “Цагийг мэдээлэх зурхай” буюу Монгол шар зурхай бол байгаль хүн хоёрын дээд зохицлыг маш сайн тооцсон, Монгол төрийн сонгодог зурхай. Гол нь байгаль дэлхийн аяг, араншинг үндэслэж, цагаан сар нэгдүгээр сарын 28-нд эхлэх нь зүйтэй гэж үзэж байна. Ер нь нэгдүгээр сарын 20-оос цаг агаар уярчихна. Би 2004 оны нэгдүгээр сарын 23-нд цагаан сараа тэмдэглэхэд яг өнөөдрийнх шиг дулаахан, цас хайлж байсан. Хэтэрхий шашны талыг баримталж байгаагийн улмаас монголчууд цагаан сараа буруу өдөр тэмдэглэж байна. Яагаад хоёрдугаар сарын 28-нд цагаан сараа тэмдэглэх нь буруу вэ гэхээр О.Жамъян гуай нэгэнтээ “Төгс буянт зурхай байгаль,



дэлхий, Монголын цагаан сартай таарахгүй байна. Орчин үеийн он тооллоор нэгдүгээр сарын 21-ээс хоёрдугаар сарын 21-ний хооронд цагаан сараа тэмдэглэх нь зүйтэй” гэж хэлсэн удаатай. Сүүлийн жилүүдэд монголчууд цагаан сараа буруу өдөр тэмдэглэх нь ихэслээ. Иргэд ч төөрөгдөлд орж, бухимдаж байна. Энэ жилийн тухайд гарцаагүй нэгдүгээр сарын 28-нд цагаан сараа тэмдэглэх нь зөв.



Данзанчойсон: Монголчууд хоёрдугаар сарын 27-ндөө золгоно



/Данзанчойсон хийдийн гэлэн/

Монголчууд нэгдүгээр сарын 28-нд золгоно гэж зарим хүмүүс яриад байгаа. Харин зарим нь

хоёрдугаар сарын 27-нд хаврын тэргүүн сар гарна гэж ярьж байна. Өдөр тасарч, давхарддаг гэдэг утгаараа Төгс буянтын зурхай шар зурхайгаас өөр. Манай Төгс буянтын зурхайд

гурван жилд нэг удаа илүү сар гардаг уламжлалтай. Энэ дагуу энэ жил өвлийн дөрвөн сартай учир хоёрдугаар сарын 27-нд золгох нь зөв. Шар зурхайд өдөр тасарч, давхцана гэсэн ойлголт байдаггүй, эр эм сараараа тооцдог учраас нэгдүгээр сарын 28-нд золгохоор тооцсон нь бий. Монгол оронд өмнө нь шар зурхай, Төгс буянтын зурхайн аль алиныг нь баримталдаг лам нар байсан. Гэхдээ монголчууд Төгс буянтын зурхайн ёсны дагуул золгодог. Хятад гэх мэт Азийн улс орнууд шар зурхайн дагуу нэгдүгээр сарын 28-даа золгох байх. Харин манайх хоёрдугаар сарын 27-ндөө золгоно. Хар ухаанаар бодсон ч, энэ сарын 28-нд манайд идэр ес дуусаагүй байна шүү дээ.



З.Санждорж: Дахиж маргахгүй, Төгс буянтын зурхайн дагуу уламжлалт баяраа тэмдэглэнэ гээд тохирчихсон шүү дээ

/Монголын бурханы шашинтны “Шинэ төв”-ийн тэргүүн, “Их хүрээ” хийдийн халба нотун хан/

Өмнө нь Цагаан сарыг хэзээ хийх тал дээр маргаан гардаг байсан. Гэхдээ албан ёсоор төр засаг, шашныхан хоорондоо ярьсны үндсэн дээр Үндэсний эрх чөлөөний 100 жилийн ойгоор энэ асуудалд цэг тавьсан. Дахиж маргахгүй. Төгс буянтын зурхайн дагуу уламжлалт баяраа тэмдэглэнэ гээд тохирчихсон шүү дээ. Үндэсний эрх чөлөөний 100 жилийн ойгоор цаг тооны бичгээ 2012-2024 он хүртэлх “Монгол Үндэсний цаг тооны бичиг” болгож, хэвлээд иргэдэд үнэгүй бариад болгосон. Гэтэл дахиад ийм асуудал гарсанд харамсч байна. “Монгол Үндэсний цаг тооны бичиг”-ийг ШУА-тай хамтран гаргасан. Эх хувь нь БСШУСЯ-нд хадгалагдаж байдаг юм. Ингээд бараг 100 жил маргахааргүй болсон. 2012 оноос хойш маргаан гараагүй. Гэтэл 2017 онд дахин маргаан гарч эхэллээ. Гол шалтгаан нь Хятадын шар зурхай, Төгсбуянтын зурхайн хоёр тоолол хоорондоо зөрөнд оршиж байгаа юм. Та бүхэн “Монгол Үндэсний цаг тооны бичиг”-ээ хараарай. Цагаан сарын шинийн нэгэн хоёрдугаар сарын 27-нд байна.

Нэрний тухайд ч маргадаг байсан. Харин арвандолодугаар жарны Алтан унжлагат хэмээн гал тахиа жил гээд аль 2011 онд бодоод, батлуулаад цаг тооны бичгээ гаргачихсан байна. Зурхайч М.Намсрай гуай өөрөө ч мэдэж байх учиртай. Бидэнтэй хамт ярилцлагад орж, дахиж маргаж мэтгэлцэхгүй гэж ярьж байсан хүн хувийн эрх ашгийн үүднээс дахин энэ асуудлыг сөхөх шиг боллоо. Хувийн ашиг сонирхлын үүднээс олон нийтийг төөрөгдүүлж буйд харамсч байна. Ний нуугүй хэлэхэд, “Монгол Үндэсний цаг


тооны бичиг” гарч, өөрийнх нь календар борлуулалтгүй болсонтой холбоотойгоор ийм мэдэгдэл хийсэн байж магадгүй. Ер нь ч тэгээд хувийн эрх ашгийн үүднээс ард түмнийг дахин төөрөгдүүлэх хэрэггүй гэдгийг зориуд хэлье. Манай ард түмэн ч төөрөгдөх шаардлагагүй. Нэгэнт тогтчихсон асуудал шүү дээ. Яах вэ, шар зурхай, Төгс буянт зурхайтай зөрөх тохиолдол гарна. Шар зурхайн цагийн хуваарь нь халуун дулаан уур амьсгалтай оронд таарсан байдаг.

Өөрөөр хэлбэл, хуучин монгол бичиг гадарладаг настай хүмүүсийн хувьд аль эрт 100 жилийн өмнө гаргачихсан урд зүгийн календарыг л хуулахаас бус, өөрсдөө зохиодоггүй сөөг тал ажиглагддаг. Төгсбуянтын зурхайн хувьд цаг агаар, Монгол Улсын одоо байгаа газар нутгийн байршилд яв цаг тохирсон байдаг юм. Жилийн жилд ингэж маргах хэрэггүй. Би дээр дурьдсан шүү дээ. Монголчууд “Монгол Үндэсний цаг тооны бичиг”-тэй болсон. Тийм байтал нэг нэгийг үгүйсгэж, энэ жил ч гэсэн маргаан гаргаад байх шаардлагагүй байсан юм. Гандантэгчинлэн хийдийн байр суурь ч бидэнтэй адилхан байгаа. Бурхны шашныхан өөрсдөө хоорондоо яриад тохирчихсон учраас маргах хэрэг байхгүй. Өмнө нь Монгол Улс аль зурхайг дагах вэ гэдгээ тохироогүй байхад маргах тохиолдол байсныг үгүйсгэхгүй. Гэхдээ нэгэнт шийдэгдчихсэн асуудал дээр маргах шаардлагагүй. Яах вэ, шар зурхайг ч үгүйсгэж болохгүй. Богд хааны үед Төгс буянт, шар зурхайг хослуулан хэрэглэж байсан баримт архивт байдаг юм. Хятадад нэгдүгээр сарын 28-нд цагаан сар болно гээд бид заавал хамт хийх албагүй. Нэгдүгээрт, тусгаар улс, хоёрдугаарт үндэсний Төгс буянт шинэ зурхайг дагана гэсэн шийдвэр гарчихсан учраас тэр.

С.Даваабаяр: Нэгдүгээр сарын 28-нд өвлийн хүйтэн дуусаагүй байна

/Монгол зурхайн Түвдэнлэлжээлин хийдийн эрдэмт шинжилгээний ажилтан, дэд профессор/

Хоёр юмс нэг нэгийг үгүйсгэж чаддаггүй гэх ойлголт бий. Өөрөөр хэлбэл, нэг нь нөгөө рүүтээ шилждэг юмс бие үгүйсгэж чаддаггүй. Шар зурхайг Чингисийн зурхай гэж хэлж болохгүй. Чингис хааны үед шар зурхай байсан эсэхийг хэн ч мэдэхгүй. Тэгэхдээ Хятадын шар зурхай Төгсбуянтын зурхай руу шилжиж болдог. Нэг үгээр хэлбэл, тооцооллыг нь шилжүүлсний үндсэн дээр Төгс буянтын зурхайг гаргаад ирж болно. Эсрэгээр Төгс буянтын зурхайгаар Хятадын шар зурхайн тооллыг бодоод цаг тооны бичгийг нь хийчихэж бас болно. Эх бичгүүд нь ч бий. Гэхдээ Хятадын шар зурхайн дагуу цагаан сараа тэмдэглэнэ гэж ярьж буй хүний гол сонирхол нь хэр том байгаа бол. Хатуухан хэлэхэд, магадгүй хэдэн бор төгрөгийн сонирхол явж байхыг үгүйсгэхгүй. Дээр үед хаанд өргөмжлөгдсөн хүн өөрийнхөө цаг тооны бичгийг гаргаж байсан түүх бий. Өөрийн улс орны түүхийг өөрийн албан ёсны цаг тооны бичгээр хөтөлж, түүхийн хуудаснаа үлдээдэг байсан. Ингэж яривал улс орны тусгаар тогтнолтой холбоотой асуудал хүртэл яригдана. Гэтэл ийм том ашиг сонирхлын төлөө хувь хүний жижиг эрх ашгаа хойш тавих хэрэгтэй шүү дээ. Зурхай гэдэг хүмүүсийн тоглоом, тохуу хийдэг ажил биш. Хятадад цагаан сар нэгдүгээр сарын 28-нд болно. Харин тэр үед манайд өвлийн тэсгим хүйтэн дуусаагүй байна. Төв Азийн хамгийн өндөрлөг хэсэгт оршдог шүү дээ, манайх. Өөрсдийн улсын цаг уур, газар зүйн байршилд нь тохирсон цаг тооны бичгийг эрдэмтэд хийчихсэн байхад түүнийг нь хэн нэгэн үгүйсгэж, тоглож болохгүй. Шар зурхай, эсвэл Төгс буянтын зурхайн аль нь зөв эсэхийг шүүх шаардлагагүй. Угтаа бол хоёуланг нь үгүйсгэж болохгүй. Гагцхүү Монгол улс яагаад Төгс буянтын зурхайг хэрэглэх ёстой юм бэ гэдэг нь л хамгийн чухал. Буддын шашин манай оронд дэлгэрээд 500 гаруй жил болж байна. Аливаа улс орны шашин нь ёс заншилтайгаа ус, сүү шиг сүлэлдсэн байдаг. Тэгэхээр монгол ёс уламжлалаа дагаж гээвэл заавал Буддын шашны Төгс буянтын зурхайг хэрэглэх шаардлагатай болно. Буддын шашныхан шинийн найман, 15, 30-нд тэнгэрт асар харагдаж байх тэр үеийг тооцон бодож, тэр үед нь бясалгал хийж, шашны зан үйлээ явуулдаг.



Энэ өдрүүдийг зүгээр ч нэг сонгосон юм биш. Шинжлэх ухаанаар батлагдчихсан хүний бие организмд асар их нөлөөтэй байдаг. Түүнчлэн, хаврын цаг эхлээд дуусах хугацаа нь хоёуланг нь нийлж байдаг. Хятадын шар зурхайд хаана явж буй нь хамаагүй, зөвхөн эхлэл, төгсгөлийн хугацааг чухалчилдаг. Төгс буянтын зурхайн хувьд өдөр бүрийн явцыг тооцдог. Эцэст нь хэлэхэд, хэрэв үнэхээр буддын шашинт хүн мөн л юм бол Төгс буянтын зурхайгаа дагах хэрэгтэй. Шар зурхай, Төгс буянтын зурхайд зөв буруу гэсэн ойлголт байхгүй. Гагцхүү тусгаар тогтнол, ёс заншил, газрын байршлын асуудал л яригдана. Тиймээс цагаан сарын шинийн нэгэн хоёрдугаар сарын 27-нд тохионо.

Хүчингүйд тооцов

Самдангийн Чулуунбаатар /ФМ55053112/-ын Орхон аймгийн Баян-Өндөр сумын Согоот багийн 6-19-31 тоотод байрлах эрхийн улсын бүртгэлийн Y-2101011270 дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг хүчингүй болгов.

Цэнд овогтой Цэсүрэнгийн улсын бүртгэлийн Y-2205012633 дугаартай 0050297 тоот орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээг гэсэн тул хүчингүйд тооцов.

Ч.Баянжаргалын (регистрийн дугаар: ФЖ62031202) өмчлөгчийн Y-2205016024 Улсын бүртгэлийн дугаартай байрны гэрчилгээг гэсэн тул хүчингүйд тооцов.

Зар Зар Зар

Цэнгэлзүхийн хажууд “Хурь”-ын байранд 1 өрөө байр яарна

Утас: 96689101

ЧУХАЛ СЭДЭВ

Хэзээ шинжлэх талаар маргалдаад байх зүйлгүй

Д.Чойжамц: Хэзээ шинжлэх талаар маргалдаад байх зүйлгүй

/Гандантэгчинлэн хийдийн хамба/

Богд хаант Монгол Улс 1911 онд тусгаар тогтнолоо зарлаж Богд Жавзандамба хутагт хаан ширээнд заларсан үеэс, Төгс буянтын зурхайн ёсоор явна гэж шийдсэн байдаг. Манжийн дарлалаас гарч, Төгс буянт зурхайн ёсоор явна гэсэн шүү дээ. Бусдын эрхшээлд, Манжийн дарлалд явсан учраас шар зурхайг хэрэглэж явсан үе бий. Сүм хийдийн газрууд Төгс буянт зурхайгаа баримталдаг. Яагаад гэвэл Төгс буянтын зурхай монголчуудын амьдралтай ойр их дөхүү байдаг. Тиймээс

ч бид Төгс буянтын зурхайгаа л баримтлах нь зөв. Тэгэхээр хаврын тэргүүн сарын шинийн нэгэн ирэх хоёрдугаар сарын 27-нд тохиож байгаа. Энэ өдөр л шинэлнэ. Бид хэзээ шинэлэх талаар маргалдаад байх зүйл байхгүй ээ. Тэр шар зурхайн хувьд суурин амьдралтай хүмүүсийн зохиосон зурхай юм. Тиймээс өдрүүдэд шахаад хийчихсэн байдаг. Өөрөөр хэлбэл, сарын өдрүүдийг шахаж хийдгээрээ ялгаатай. Харин Төгс буянтын зурхай сарны хэлбэрийг авч явдаг учраас шар зурхайгаас арай өөр. Монголчуудад яг таарсан. Сарын зарим нэг өдөр шинийн долоон хоёр байх жишээтэй.

Орчин үеийн шинжлэх ухаанаар ярих юм бол сар, дэлхий хоёрын ойртох, холдох зайнаас хамаарч байгаа юм. Сар, дэлхий хоёр холдчихоод байгаа үед хоёр хоночиноод байхад сарны хэлбэр огт өөрчлөгдөхгүй байгаа. Түүн дээр нэмэлт хийдэг. Ойртсон үед дорхноо сарны хэлбэр өөрчлөгдчихөж байгаа учраас шинийн долоонх биш шинийн наймны сарны хэлбэртэй болчихож байгаа. Тиймээс өдрийг нь тэгж тааруулдаг юм. Нүүдэлчин амьдрал сарныхаа хэлбэрийг л дагаж ирсэн. Манай шашны номлол ч сарны хэлбэрээр явж байгаа зурхайгаараа хурдаг. Тухайлбал, 29-нд хамгийн



нарийсаад бараг харагдахгүй болчихсон үед 29-ны хурлыг хурдаг. Битүүнд бол саргүй байх

үе болохоор битүүний хурлаа хурдаг. Харин шинийн наймаанд сар яг тал дугуй болдог. Энэ хэмжээсүүдээр л хурал номоо хурдаг.



Л.Тэрбиш: Шар зурхай бол Хятадын зурхай

/Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Монголын Үндэсний ШУА-ийн академич, шинжлэх ухааны доктор (ScD), профессор, зурхайч/

Гандантэгчэнлэн хийд, Бурхны шашны зонхилох байгууллагууд Төгс буянтын зурхайн дагуу энэ жил монголчууд хоёрдугаар сарын 27-нд шинийн нэгэн тохиож байгаа гэж үзэж байгаа. Миний хувьд ч гэсэн хоёрдугаар сарын 26-нд битүүний өдөр, хоёрдугаар сарын 27-нд шинэлнэ гэж үзэж байгаа. Тахиа жилийн хаврын эхэн сарын шинийн нэгэн нь хоёрдугаар сарын 27-нд тохиож байгаа. Шар зурхай бол Хятадын зурхай гэж хэлмээр байна. Шар зурхай гэж юм ертөнц дээр байхгүй Хятадын хааны тоолол буюу хуанлийн тооллын зурхайг зарим нэг учир үл мэдэх хүмүүс шар зурхай гэж хэлээд байгаа бололтой юм. Тэр нь "хуань" гэсэн ханз үсэг нь "Хаан", "Шар" хэмээн хоёр янзаар орчуулагддагийг л "Хаан" гэдгийг нь эндүүрч "Шар" хэмээн орчуулсан нэгэн болхи орчуулагчаас уршигласан биз.

Ж.Одгарьд: Шашны зонхилох байгууллагуудаас барьж байгаа зурхайн ёсоор шинэлэх нь зөв

/Монголын Бурхан шашны төв Гандантэгчэнлэн хийдийн Олон нийттэй харилцах албаны ажилтан/

Гандантэгчэнлэн хийд, бурхны шашны зонхилох байгууллагууд, төр засгийн зүгээс ч нийтлэг мөрдөж буй он тооллын зурхайгаа алдаа мадаггүй гэж хүлээн зөвшөөрдөг. Энэ дагуу ирэх жилийн сар шинэ буюу тахиа жилийн хаврын эхэн сарын шинийн нэгэн нь хоёрдугаар сарын 27-нд тохиох хэвээрээ. Хоёрдугаар сарын 26-нд бичин жилийн өвлийн адаг сарын битүүн тохионо. Хувь хүний хийж байгаа мэдээлэл дээр бид байр суурна илэрхийлэх шаардлагагүй. Ард иргэд олон хүний өөр, өөр мэдээлэлд автахгүйгээр төрийн барьж байгаа баримтлал, шашны зонхилох байгууллагуудаас

барьж байгаа зурхайн ёсоор голчилж явбал зөв болов уу. Төгс буянтын зурхайн ёсоор сар ургах, шингэх, гариг эрхэсийн нөлөөллөөс шалтгаалаад давхцах, тоо нь зөрөх тохиолдол байдаг. Төгс буянтын зурхай түүнийг нь тааруулж, нэлээд төгөлдөржүүлсэн байдаг. Түүнээс биш шууд нарны тоолол шиг тоо дараалуулаад, сар ургах, шингэхийг тооцоолохгүй байж болохгүй. Үүнийг дагаж буй Төгс буянтын зурхай бол гарцаагүй Монгол нутагт, Монгол газарт зохицсон гэж хэлж болно. Мөн зурхайн ёсонд хойд уул, эсвэл Богд уулын орой дээр гарахад зурхай зурах ёс нь зөрүүтэй гарна гэх мэтээр газрын байрлал тодорхойлох, од эрхэсийн ургах шингэхийг тооцоолоход зөрүүтэй гарна гэж үздэг. Сарны үзэгдэх хугацаа газар газар ондоо байдаг тул нэгдүгээрт, орон



нутгаар нь салгаж, хоёрдугаарт тухайн газар орны онцлогийг харуулж зурдаг. Тиймээс Монгол нутагт баримтлаж байгаа Төгс буянтын зурхай бол энэ бүгдийг судлаж, олон талын тооцоолуудыг үндэслэж байж гаргадаг. Шар зурхайн хувьд гол эх сурвалж, зан үйл нь байсан шар зурхай мэтийн зарим зүйл нь тодорхой бус зурхайнуудыг илүү нарийн тооцоолж, тодорхой болгож тавьснаараа Төгс буянтын зурхай давуу. Тухайн цаг үед зурхайн ухаанд мэргэшсэн олон эрдэмтэн, мэргэн хуваргууд судлаж гаргаж ирсэн.

Бурхны шашин бол гурван үе дэлгэрсэн байдгаас гуравдугаар үеэс буюу XVI зуунаас шарын шашин дэлгэрсэнтэй холбоотойгоор Төгс буянтын зурхай бий болсон. Гэхдээ өмнө огт байхгүй байгаад гэнэт гараад ирсэн ч биш, өмнө нь байсан шар зурхай мэтийн зарим зүйл нь тодорхой бус зурхайнуудыг илүү нарийн тооцоолж, тодорхой болгож тавьснаараа Төгс буянтын зурхай давуу. Тухайн цаг үед зурхайн ухаанд мэргэшсэн олон эрдэмтэн, мэргэн хуваргууд судлаж гаргаж ирсэн.



Б.Энхбат: Хоёрдугаар сарын 27-нд хаврын тэргүүн сар гарна


/Гандантэгчэнлэн хийдийн зурхайч/

Жил бүр л цагаан сарыг хэдэн сарын хэдэнд тэмдэглэх талаар маргаан гардаг болж. Монголчууд цагаан сараа ирэх сард тэмдэглэнэ. Тодруулбал, хоёрдугаар сарын 26-нд битүүрч, 27-нд буюу шинийн нэгний өдөр золгуутаа хийж юм. Зурхайч М.Намсрай гэдэг хүн цагаан сарын шинийн нэгэн энэ сарын 28-нд болно, энэ өдөр хаврын тэргүүн сар

эхэлнэ гэсэн зүйл ярьсан байна билээ. Энэ жил өвлийн сар илүү байгаа. Манайх Төгс буянтын зурхайгаар бодон тооцоолж, газрын байршилдаа тохируулан зурдаг. Энэ дагуу хоёрдугаар сарын 27-нд хаврын тэргүүн сар гарна. Нэгдүгээр сарын 28-нд шинэлнэ гэж ярьсан хүмүүсийн тухайд Хятадыг дуурайж буй хэрэг. Ер нь хойшдоо Төв Гандантэгчэнлэн хийдийн зурхай зурлагыг дагах нь зүйтэй болов уу. Төрийн түшээд маань ч гэсэн золгуутаа хийж,

Гандантэгчэнлэн хийдэд ирж мөргөдөг шүү дээ. Төр шашны гэж байдаг. Түүнийгээ л дагах хэрэгтэй. Хэн нэгэн хүн монголчуудынхаа жилдээ ганц удаа тэмдэглэдэг уламжлалт баярыг үймүүлж болохгүй. Дашрамд хэлэхэд, цагаан сар дөхөхөөр л олон нийтийг төөрөгдүүлсэн мэдэгдэл хийдэг хүмүүсийг гэр, засгаас чшалгаж, асуудлыг нэг тийш нь болгоход гэмгүй байх. Нангиадын шар зурхайд хааны зарлигийн дагуу өдөр тасарна, давхардана гэсэн

зүйл байдаггүй. Харин Төгс буянтын зурхайд зарим өдөр давхцаж, тасарна. Илүү сараа бодно. Европын тоололд ч гэсэн дөрвөн жилийн давтамжаар 29 хоногтой сар байдаг шүү дээ. Манайх хоногоо нэмээд илүү сараа оруулдаг. Азийн улс гээд бүгд адилхан байх албагүй. Тэр бүү хэл, Увс, Ховд аймаг ч Улаанбаатар хоттой нэг цагийн зөрүүтэй байдаг. Гэтэл бүр өөр оронтой нэг өдөр таарна гэдэг байж болохгүй гэдгийг сайн ойлгох хэрэгтэй.



Тал нутгийн цахим мэдээлэл



ДУУЛГАХ СОНИН

Шатрын багш, дасгалжуулагчийн анхны ангийн төгсөлт боллоо

Ж.ОТГОН

Хүн төрөлхтний оюун санааны гайхамшигт бүтээлүүдийн нэг шатар гэгддэг. Тиймээс ч шатар хүүхдийн төлөвшил, хүмүүжил, хөгжилд үнэлж баршгүй олон эерэг нөлөө үзүүлдэг шилдэг загвар болдог гэдгийг сурган хүмүүжүүлэгчид, эрдэмтэд нотолсон байдаг. Тэгээд ч өнөөгийн хэт цахимжсан үед шатрын хүнийг байгалиар нь сэтгэн бодуулж чадах ач холбогдол нь улам илүү болж байгаа юм. Угаасаа шатрыг нүүдлийн ахуй амьдралтайгаа нягт уялдаа холбоотойгоор уламжлан хөгжүүлж, төр улсаа ч "Шатар ухаан"-аар урлаж ирсэн баялаг түүхтэй шатарч ард түмэн бол монголчууд. Тэгвэл МУБИС-ийн захирал Д.Мөнхжаргал, Монгол Туургатны шатрын холбооны гүйцэтгэх захирал Н.Түвшинтөгс нарын санаачилгаар Монгол Улсад анх удаа шатрын багш дасгалжуулагч бэлтгэх ангийг нээсэн байна. Энэхүү ангийн нэг жилийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, өнөөдөр анхны 13 төгсөгчдөд багшлах эрхийн дипломыг нь гардууллаа. Төгсөгчдөд диплом гардуулах ажиллагаанд УИХ-ын гишүүн Д.Лүндэжаргал, Ё.Баатарбилэг, БСНУСЯ-ны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийн газрын дарга С.Чинбат, Монгол Туургатны шатрын холбооны Ерөнхийлөгч Ц.Оюунбаатар, гүйцэтгэх захирал Н.Түвшинтөгс зэрэг албаны хүмүүс оролцлоо.

Шатрын багш, дасгалжуулагчийн анхны ангийн төгсөгчдийндарга З.Цэнгэнбаяр "Манай ангийн хамт олон жил гаруйн хугацаанд амжилттай суралцаад, бүгдээрээ шатрын багш, дасгалжуулагчийнхаа ажлыг



хийгээд явж байгаа залуучууд байгаа. Бидний хувьд дараа дараагийн шатрын аваргуудыг бэлтгэх, шатрын ангид ала олон олон элсэгчдийг бэлтгэн өгөх болно. Манай ангийн хамт олон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд шатар сургах ажил санаачлан хийхээр бэлтгэж байгаа.

Бидний энэ гэгээн ажлыг маш олон хүн дэмжих байх гэж найдаж байгаа" гэлээ. Үнэхээр ч сүүлийн үед өсвөрийн шатарчдыг системтэй бэлтгэх, сургах асуудал тулгамдаад байгаа. Тиймээс ч ийнхүү мэргэжлийн шатрын багш, дасгалжуулагчдыг бэлтгэж эхэлсэн байна. Хөтөлбөрийг санаачлагчид МУБИС-ийн дэргэд "Шатрын багш" нэртэй

клубыг Монголын шатрын холбооны дэмжлэгтэйгээр байгуулж, олон улсын чансаа тооцдог тэмцээнүүдийг тогтмол зохион явуулдаг болсон нь бага зардлаар олон улсын ур чадвараа дээшлүүлэх боломжийг шатарчдад олгодог болжээ. Цаашид шатрыг ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулахад энэ ангийг нээсэн нь чухал алхам болох юм гэдгийг МУБИС-ийн захирал Д.Мөнхжаргал онцолж байлаа. Шатрын багш, дасгалжуулагчийн ангийн оюутнууд манай улсын шилдэг гэж хэлж болох бүх шатарчид хичээл заасан байна. Тухайлбал, Монгол Улсын гавьяат тамирчин ОУМ Л.Мягмарсүрэн, Гавьяат дасгалжуулагч ОУМ

П.Жигжидсүрэн, Гавьяат багш, ахмад мастер Д.Ламжав, ОУШХМ, Улсын долоон удаагийн аварга Ж.Лхагва, ОУМ Ц.Лхагвасүрэн, ОУШХМ Ч.Хүрэлбаатар, спортын мастер, Улсын аварга, профессор Ц.Энхбат, Төрийн соёрхолт, спортын мастер профессор Р.Энхбат, спортын мастер Ц.Энхбат, С.Болдбаатар, дэд мастер Д.Дамдин, дэд мастер Л.Уржиндорж, ОУХМ Л.Тогоохүү, МУБИС-ын эрдэмтэн багш нар болон ОХУ-ын Их мастер А.Фоминых зэрэг мундаг хүмүүс урилгаар хичээл заасан байна.

Алдарт багш нарыг нэг ОУШХМ, Улсын долоон удаагийн аварга Ж.Лхагва "Би шатартай амьдралаа холбоосноос хойш олон түүхт үйл ажиллагаанд оролцож

байсан. Түүний нэг нь өнөөдөр шатрын багш, дасгалжуулагчийн анхны ангийн төгсөлт болж байгаад баяртай байна. Монгол Улсад шатрын спортын төлөө зүтгэж байдаг байгууллага, хувь хүн олон байдаг. Үүний нэг нь шатарчид бидний хүсэн хүлээж байсан шатрын сургалтын талаар томоохон арга хэмжээ авч хэрэгжүүлэн, мэргэжлийн төгсөгчдийг бэлтгэн гаргаж өгч байгаад үнэхээр баяртай байна. Тиймээс ч энэхүү гайхалтай сайхан үйлсийг бүтээж байгаа Монгол Туургатны шатрын холбооны удирдлагууд болоод МУБИС-ийн захирал Д.Мөнхжаргал нарт тусгайлан баярлаж, талархаж байгаагаа илэрхийлээр байна" гэв.

Улаанбаатарт:

Маргааш
Эдөр -12
Шөнө -22

Нөгөөдөр
Эдөр -12
Шөнө -22

Өдрийн зурхай

Өвлийн дунд илүү цагаан хулгана сар зургаан цагаан мэнгэтэй хар луу өдөр

Наран ургах шингэх: 08.41-17.14

Үс засуулбал: Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ



Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр андай тангаргаас няцах, дайсныг нолхруулах үйлд сайн. /луу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/ Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал айтшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрэв дуугарвал зочин ирэх, тагнай загатанал алгалан болох, бие татвал эцэг эх цочих, хол татвал тэмцэл болно. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

КИНО ЕРТӨНЦ

"Сайн аав" энэ сарын 20-нд нээлтээ хийнэ

"Про стар" филмсийн бүтээл "Good Dad" "Сайн Аав" Монголын уран сайхны кино энэ сарын 20-нд нээлтээ хийхээр товлосон байна. Үзэгчдийн дунд маш их хүлээлт үүсгэж буй уг киноны санаачлагч Д.Амаржаргалын хүсэлтээр уг киног таксини жолооч, мундаг ав гэж ард түмэнд танигдаж байсан Т.Даваасүрэн агсны гэгээн дурсгалд зориулан бүтээжээ. Тус киноны продюсерээр "Про стар" филмсийн захирал С.Чулуунтогтох ажилласан юм. Мөн тэрбээр ээлжит уран бүтээлийнхээ талаар дурьдахдаа "Манай студийн бүтээж байгаа бас нэг хүлээлт үүсгэсэн бүтээл бол "Шидэт хуудас" бүрэн хэмжээний хүүхэдгүй кино юм. Энэ бүтээл маань 70 гаруй хувийн амжилттай явагдаж байгаа. 2017 оны

хавраас олны хүртээл болно" гэв. 2D буюу зурмал "Шидэт хуудас" бүрэн хэмжээний хүүхэдгүй киноны ерөнхий найруулагч С.Бүжин Good DAD "Сайн аав" уран сайхны киноны зохиолыг бичиж, өөрөө ерөнхий найруулагчаар нь ажиллажээ. Тэгвэл Монголын кино урлагт эмэгтэй найруулагч хуруу дарам цөөн гэдгийг үзэгч олон мэдэх билээ. Эмэгтэй хүний торгон мэдрэмж, нямбай ажиллагаа харагдсан уг кино группт олон чадварлаг уран бүтээлч хамтран ажилласан байна.

Киноны голд дүрд жүжигчин найруулагч, МУСТА С.Баттулга, Ш.Жавхлан, таван хүүхдийн дүрд Т.Даваасүрэн агсны том охин Д.Энхжин,



И.Мөрөн, Б.Хачин, Э.Индра, Б.Ариун-Итгэл нар тогложээ. Мөн туслах дүрүүдэд жүжигчин, МУСТА Н.Ялагт, С.Батзориг буюу Ишчү, Т.Энэрэл зэрэг олон чадварлаг жүжигчид оролцон тогложээ. Ийнхүү Монголын кино урлагт шинэ өнгө нэмсэн сайхан уран бүтээлийн хэсгээс хүргэж байна.

ХӨЛБӨМБӨГ

Кавани "ПСЖ"-тэй 2020 он хүртэл гэрээгээ сунгана

Францын алдарт "ПСЖ" клубын довтлогч Эдинсон Кавани багтайгаа гэрээгээ сунгахад тун ойрхон байгаа ажээ. Бүр тодорхой хэлбэл, энэ сардаа багтаад шинэ гэрээнд гарын үсэг зурах юм байна. Тэгэхдээ Уругвай довтлогч багтайгаа 2020 он хүртэл гэрээгээ сунгах ажээ. Шинэ гэрээний дагуу түүний цалин ч тодорхой хэмжээнд нэмэгдэнэ. Тэрбээр энэ улиралд Францын лигт 19 тоглолтод оролцож, 18 гоол оруулчихаад байгаа юм.



TENGIS



Аз жаргал, зовлон гуниг, хайр дурлал, хардалт, амжилт, бүтэлгүйтэл гээд л хар, цагаан хосолж байдаг хүний амьдралд бид төрөхдөө "Амьдралын сурах бичиг"-ээ өвөртлөөд ирдэг бол хэчнээн сайхан! Өөрийн биеэр туулж байж л амьдралын зах зухаас мэдэж, сурч, туршлагажиж ухаардаг. Энэ бол "Амьдралогч" юм. Тэгвэл амьдралынхаа 2 дахь үеийн хямралд орсон гэр бүлийн хос, амжилттай яваа ч заяаны ханна харахан олоогүй бүсгүй, залуу халуун насныхаа алдаа, оноог дэнслүүлэн яваа оюутан охин болон киноны бусад дүрүүдийн аз жаргалын төлөөх тэмцэл болон тэдний санаанд оромгүй сонголтуудыг "Амьдралогч" романтик инээдмийн уран сайхны киноноос үзээрэй.



Assassin's Creed буюу Алуурчны үнэмшил видео тоглоомоос сэдэвлэн бүтээв.



Жаззхогжимчин Сибастян жүжигчин болох хүсэл мөрөөдөлтэй Миа бүсгүйд дурлана. Миа киноны шалгаруулалтуудад орохын хажуугаар кино одуудад кофе зөөдөг бол жаззхогжимчин Сибастян ядруухан баранд коктэйлийн үдэшлэгийн хөгжим тоглож амь зогоодог байв. Амжилтад ойртохын хэрээр тэд тэдний эмээгхэн хайрыг сэвтээх хүнд шийдвэрүүдийг гаргах хэрэгтэй болно.